



МОНГОЛ УЛСЫН САЙД,
ОЛИМП, НИЙТИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН
ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 12 сарын 15 өдөр

Дугаар А/07

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Хууль тогтоомжийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь хэсэг, Монгол Улсын Их хурлын 2021 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн "Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай" 12 дугаар тогтоолын тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Биеийн тамир, спортын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн үзэл баримтлал, нэмэлт өөрчлөлт оруулах төсөл боловсруулах, судалгаа, хэлэлцүүлэг хийх ажлын хэсгийг дор дурдсан бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:

Э.Тэмүүжин

Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын үндэсний даргын ажлын албаны дарга

Ажлын хэсгийн дэд дарга:

Д.Жаргалсайхан

Биеийн тамир, спортын улсын хорооны дарга

Гишүүд:

Д.Энхгэрэл

Улсын Их хурлын Редакци, кодификацийн ахлах зөвлөх

Л.Лхагвасүрэн

Улсын Их хурлын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны ахлах зөвлөх

Х.Энэбиш

Улсын Их хурлын Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны ахлах зөвлөх

О.Баттулга

Биеийн тамир, спортын улсын хорооны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга

Б.Нямсүрэн

Биеийн тамир, спортын улсын хорооны Спортын бодлогын хэрэгжилтийн хэлтсийн даргын үүрэг гүйцэтгэгч

О.Баасан

Биеийн тамир, спортын улсын хорооны Биеийн тамирын бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга

Ч. Зоригтбаатар

Нийслэлийн ерөнхий боловсролын спортын төв сургуулийн захирал

000047

С.Мөнх-Эрдэнэ	Биеийн тамир, спортын улсын хорооны Бодлого төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн
Х.Бакытжан	"Улаанбаатар спорт менежмент" орон нутгийн өмчид компанийн хэлтсийн дарга
Ч.Наранбаатар	Монголын Үндэсний олимпын хорооны тэргүүн дэд ерөнхийлөгч
Д.Сүрэнхорлоо	Монголын Үндэсний паралимпын хорооны дэд ерөнхийлөгч
Г.Энхсайхан	Монголын Улсын Боловсролын их сургуулийн Биеийн тамирын сургуулийн захирал
С. Жамц	Монголын Улсын Боловсролын их сургуулийн Биеийн тамирын сургуулийн зөвлөх багш-99118495

Нарийн бичгийн дарга:

Б. Өлзийбаяр Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний даргын ажлын албаны мэргэжилтэн

2. Биеийн тамир, спортын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн үзэл баримтлал, нэмэлт өөрчлөлт оруулах төслийг боловсруулах, судалгаа, хэлэлцүүлэг хийх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлэн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх арга хэмжээ авахыг Ажлын хэсгийн дарга /Э.Тэмүүжин/-д даалгасугай.

Монгол улсын сайд, Олимп,
нийтийн биеийн тамир, спортын
Үндэсний хорооны дарга



Б.БАТ-ЭРДЭНЭ